

Маргааны товч

Баянгол дүүргийн Засаг дарга “Ихсүлд” ХХК-д анх 2009 оны 537 дугаар захирамжаар тус дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт агуулах, аж ахуйн зориулалтаар 3000 м.кв газрыг 5 жилийн хугацаагаар эзэмшүүлж, 2011 оны 490 дүгээр захирамжаар талбайн хэмжээг 2238 м.кв болгон багасгасан, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 2016 оны А/654, 2022 оны А/255 дугаар захирамжуудаар 5, 15 жилээр тус тус сунгаж, 2022 оны А/326 дугаар захирамжаар талбайн хэмжээг 8038 м.кв болгон нэмэгдүүлж, 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсэн.

Улмаар дүүргийн Засаг дарга “усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс, Үерийн далангийн хамгаалалтын бүс, Цахилгааны шугамын хамгаалалтын бүсэд орсон, орон нутгийн тусгай хамгаалалтын бүсэд багтсан” үндэслэлээр нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон.

Нэхэмжлэгчээс “хариуцагч газар эзэмшилтийн байдлыг очиж үзэлгүйгээр шийдвэр гаргаж байгаа нь бодит байдалд болон холбогдох хуульд нийцэхгүй” гэх үндэслэлээр маргажээ.